



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/535

Хэрлэн сум


Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тулга констракшн" ХХК-аас аймгийн орон сууцны санд төлөх 274,581,171 (хоёр зуун далан дөрвөн сая таван зуун наян нэгэн мянга нэг зуун далан нэгэн) төгрөгийг нэхэмжлэх тухай иргэний хэрэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.1.4, 25.1.6, 25.1.7, 25.1.8 дахь заалтуудад заасан бүрэн эрхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д олгож, аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр (хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар) томилсугай.

2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нэхэмжлэгчийг бүрэн төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ